



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/35/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор:

Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер:

Э.Энхцэцэг

Утас: 70523020

Цахим хаяг: enktsetseg.e@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ц.Лүндэгмаа

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13	Шилэн дансны мэдээлэл	10
2.14	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ЗАМЫН-ҮҮД СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.БАТДУЛАМ ТАНАА

2020.02.20 № 1-6/94
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Батдулам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 17-ноос 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 2/71 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар нь “Эрүүл тохилог бүс нутаг болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагааг иргэдийн оролцоонд тулгуурласан нээлттэй тунгалаг болгож, хариуцлага хяналтыг төрийн ажлын үндсэн зарчим болгон, хүнд сурталгүй, авлигаас ангид, хууль дээдэлсэн, төрийн үйлчилгээг бий болгож, төрийн албыг нийтийн алба, төрийн үйлчилгээг нийтийн үйлчилгээ болгон өөрчилж хэвшүүлнэ.
- Эрх зүйн сургалт, сурталчилгааны болон хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын чанарыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн нэгдсэн санг баяжуулан боловсронгуй болгох, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хуульд нийцүүлэх,

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,284,520.2 мянган төгрөгөөс тооцон 65,590.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшин 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын дүн 3,281,189.2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 32,811.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 310,708.1 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	
Авлага	2,879.9	32,446.4	29,566.5
Бараа материал	32,735.1	447,105.8	414,370.7
Үндсэн хөрөнгө	2,718,502.4	2,724,327.8	5,825.4
Хуримтлагдсан элэгдэл	-400,909.3	-539,963.8	-139,054.5
Нийт хөрөнгө	2,353,208.1	2,663,916.2	310,708.1
Өр төлбөр	735.6	665.8	-69.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,352,472.5	2,663,250.4	310,777.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,353,208.1	2,663,916.2	310,708.1

Авлага дансны үлдэгдэл 29,566.5 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн авлагатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 414,370.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Гадаадын иргэн харьяатын газарт хөрөнгө оруулалтын зардлаас худалдан авсан 5 авто машиныг бүртгэснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байсныг эргэлтийн хөрөнгөнд бүртгүүлж залруулга хийлгэв.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5825.4 мянган төгрөгөөр өссөн нь 33,747.2 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, 27,921.8 мянган төгрөгөөр хасагдсанаас шалтгаалжээ. Тухайлбал:

Авто тээврийн хэрэгслийн дансанд 25.0 сая төгрөгийн авто машин, тоног төхөөрөмж дансанд 7,147.2 мянган төгрөгийн хөрөнгө /6.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 897.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан/, тавилга эд хогшил дансанд 1600.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч нийт 33,747.2 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Тоног төхөөрөмж данснаас сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 3 сарын 28-ны өдрийн 05/26 дугаар тогтоол, 12 сарын 16-ны өдрийн 11/91 дугаар тогтоолоор нийт 21625.6 мянган төгрөгийн хөрөнгө, тавилга хэрэгсэл данснаас 5,321.8 мянган төгрөгийн хөрөнгө, бусад үндсэн хөрөнгөөс 974.5 мянган төгрөгийн нийт 11251.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 12 сарын 16-ны өдрийн 11/92 дугаар тогтоолоор тоног төхөөрөмж данснаас 16,670.5 мянган төгрөгийн хөрөнгийг Соёл, спортын ордонд шилжүүлж нийт 27,921.8 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсан байна.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл дансны үлдэгдэл 139,054.5 мянган төгрөгөөр буурсан зөрүү нь 160,160.4 мянган төгрөгөөр элэгдэл байгуулсан, хасагдсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 21,105.9 мянган төгрөгөөр хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,663,250.4 сая төгрөг болж 310,777.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн данс 310,777.9 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэнээс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 888,529.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төсөв батлагдсан бөгөөд нийт зардлын 888,529.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Урсгал зардалд гүйцэтгэлээр 842308.4 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсвийг 46,220.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Орон нутгийн төсвөөс 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна. Хэмнэгдсэн 42,220.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, байна.

Төсвийн гүйцэтгэлээр цалингийн зардлыг 13,311.1 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 6,774.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 16,685.9 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 5,804.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 31.9 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 578.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,888.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,145.3 мянган төгрөгөөр нийт 46220.6 мянган төгрөгийн зардлыг төсвөөс хэмнэсэн байна.

Нэмэлт төсөв: Сумын ЗДТГ-аас хөрөнгө оруулалтын зардалд 1,976,402.8 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 226,000.0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас шилдэг сумын шагнал, барилга орон сууцны тооллого, спортын арга хэмжээний дэмжлэг, хонины цэцэг өвчний зардал зэрэгт 52,834.6 мянган төгрөг, иргэдээс өвсний үнэ 4,656.5 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 987.8 мянган төгрөг, СХС-д орох андуурагдсан орлого 160.3 мянган төгрөг, урьд оны нэмэлт санхүүжилтийн харилцахын төвлөрүүлсэн авлага 2,516.5 мянган төгрөг нийт 2,263,558.5 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс тухайн арга хэмжээнд 2,231,365.1 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 32,193.4 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэлийн үе шатанд 6 эрсдэл тодорхойлж нийт 89 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 436,128.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 423204.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 12,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага бичиж, 924.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 12,000.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 115/ШШ2017/0018 дугаар шийдвэрээр Замын-Үүд сумын Засаг даргын 2016 оны Б/43

тоот захирамжийг хүчингүй болгож Д.Даринчулуунд хууль бусаар ажилгүй байсан 10 сар 4 хоногийн хугацааны цалин хөлстэй тэнцэх олговор 12.7 сая төгрөг олгохыг даалгасан байна. ЗДТГ-ын цалингийн сангаас Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн дансанд Д.Даринчулууны цалингийн олговор нийт 12.0 сая төгрөгийг 2019 оны 3-12 дугаар саруудад 5 удаагийн төлбөрийн хүсэлтээр шилжүүлсэн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Замын-Үүд сумын ЗДТГ-нь цалингийн зардлаас барагдуулсан төлбөр 12.0 сая төгрөгийг гэм буруутай албан тушаалтан Б.Анхбаяраар төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох албан шаардлага бичив.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний гэрээ, ажлын гүйцэтгэл, тайланг шалгах нь зүйтэй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар нь цалингийн урьдчилгаа төлүүлэх тухай ДГА-2018/136/СТА-ТШЗ дугаарын 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт, давхардуулж олгосон тэтгэмжийн мөнгийг төлүүлэх тухай ДГА-2018/136/СТА-ТШЗ дугаар бүхий 3.0 сая төгрөгийн төлбөрийн актыг тус тус барагдуулаагүй байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хариуг 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 1/1086 тоот албан бичгээр ирүүлж зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.1.1 Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас 924.0 мянган төгрөгийн өвсийг эрх зүйн актгүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүйгээр малчдад үнэ төлбөргүй тараасан байна.

Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас эрх зүйн актыг үндэслэн зарлагын гүйлгээ хийх, хөрөнгийн хөдөлгөөн гарсан тухай бүр анхан шатны хүчин төгөлдөр баримтыг үндэслэн эд хариуцагчаар тайлан гаргуулж хэвших

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,615,088.85	479,552,256.35
33	АВЛАГА	2,879,934.07	32,446,424.12
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	363,381.07	239,468.12
335	Бусад авлага	2,516,553.00	32,206,956.00
3351	Байгууллагаас авах авлага	2,516,553.00	32,206,956.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,735,154.78	447,105,832.23
354	Хангамжийн материал	32,735,154.78	447,105,832.23
35410	Бичиг хэргийн материал	12,676,300.00	11,506,522.00
35420	Аж ахуйн материал	17,952,817.97	12,131,035.22
35440	Тулш, шатах тослох материал	681,000.00	577,000.00
35450	Барилгын засварын материал	411,950.00	1,833,252.95
35470	Бусад хангамжийн материал	1,013,086.81	421,058,022.06
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,317,593,051.86	2,184,363,976.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,317,593,051.86	2,184,363,976.07
392	Биет хөрөнгө	2,281,974,051.86	2,148,744,976.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,033,849,497.00	1,033,849,497.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,791,642.62	-39,990,033.82
39203	Авто-тээврийн хэрэгсэл	192,294,800.00	217,294,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-75,353,238.41	-88,480,088.42
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	158,448,802.57	143,970,497.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	-94,317,564.65	-93,877,812.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,059,275.30	86,337,489.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-60,396,810.13	-61,831,717.41
39209	Зам, гүүрийн байгууламж	889,566,565.00	889,566,565.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-88,508,453.10	-157,424,492.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	316,619,872.00	315,645,406.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-64,497,051.10	-96,315,134.02
393	Биет бус хөрөнгө	35,619,000.00	35,619,000.00
39301	Програм хангамж	2,044,500.00	2,044,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,044,500.00	-2,044,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,619,000.00	35,619,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,353,208,140.71	2,663,916,232.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	735,595.00	665,774.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	735,595.00	665,774.00
413	Өглөг	735,595.00	665,774.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	84,270.00
4136	Бусад өглөг	735,595.00	581,504.00
41361	Байгууллагад төлөх өглөг	101,095.00	309,254.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	634,500.00	272,250.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,352,472,545.71	2,663,250,458.42
51	Засгийн газрын хувь оролцоо	2,352,472,545.71	2,663,250,458.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	476,930,039.18	476,930,039.18
51101	Өмч: - төрийн	476,930,039.18	476,930,039.18
512	Хуримтлагдсан үр дүн	1,233,767,771.19	1,544,545,683.90
51210	Өмнөх үеийн үр дүн	1,233,767,771.19	1,233,767,771.19
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	310,777,912.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	641,774,735.34	641,774,735.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,353,208,140.71	2,663,916,232.42

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	1,631,688,603.00	3,591,967,146.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	853,209,503.00	2,707,438,146.00
120	Нийтлэг татварын бус орлого	849,327,671.00	2,260,882,323.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	849,327,671.00	2,260,882,323.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	849,327,671.00	2,260,882,323.00
122	Тусламжийн орлого	3,881,832.00	446,555,823.00
122001	Хандив тусламж /дотоод/	3,881,832.00	446,555,823.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	778,479,100.00	884,529,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	760,479,100.00	884,529,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	760,479,100.00	884,529,000.00
1330	Төсвийн захирагчдаас	18,000,000.00	00.00
133005	Төсвийн сөрөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	18,000,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,759,533,457.38	3,274,957,861.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	957,533,457.38	1,096,602,031.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	915,094,704.88	1,044,081,412.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	465,247,564.01	520,005,427.00
210101	Үндсэн цалин	465,147,181.01	507,910,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	100,383.00	12,094,527.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,311,125.86	64,516,102.95
210201	Тэтгэврийн даатгал	40,077,244.64	44,286,021.95
210202	Тэтгэмжийн даатгал	4,106,434.99	4,455,285.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,909,778.83	4,593,707.00
210204	Ажилгүйдлийн даатгал	930,338.09	1,016,461.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,287,329.31	10,164,628.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,949,803.86	53,189,428.36
210301	Гэрэл, цахилгаан	5,549,823.00	17,649,841.84
210302	Түлш, халаалт	43,368,025.06	32,348,528.52
210303	Цэвэр, бохир ус	3,031,955.80	3,191,058.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,027,989.10	91,039,221.32
210401	Бичиг хэрэг	19,887,186.20	26,965,206.00
210402	Тээвэр, шатахуун	12,034,868.00	38,243,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,164,376.50	6,314,435.00
210404	Ном, хэвлэл	1,807,800.00	355,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, турган элэгдэх, ахуйн эд зүйлс	129,200.00	731,551.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,524,558.40	17,709,189.32
2105	Нормативт зардал	00.00	3,194,110.00
210502	Хоол, хүнс	00.00	2,826,110.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	368,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,019,340.00	9,727,378.92
210602	Тавилга	5,079,970.00	584,560.00
210604	Урсгал засвар	1,939,370.00	9,142,818.92
2107	Томилдолт, зочны зардал	12,975,680.00	15,179,900.00
210702	Дотоод албан томилдолт	8,289,080.00	12,268,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,686,600.00	2,911,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,833,009.20	88,266,077.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,140,159.20	87,483,117.73
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	203,250.00	237,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,600.00	194,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	120,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	177,730,192.85	198,963,766.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,031,862.00	37,534,333.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,289,000.00	1,269,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	161,409,330.85	160,160,433.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,438,752.50	52,520,618.64
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	37,778,752.50	42,220,618.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,660,000.00	10,300,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,660,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	10,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	802,000,000.00	2,178,355,830.56
2200	Дотоод эх үйсвэрээр	802,000,000.00	2,178,355,830.56
220001	Барилга байгууламж	802,000,000.00	2,178,355,830.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-127,844,854.38	317,009,284.09
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,137,291.52	6,231,371.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	6,231,371.38
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	15,137,291.52	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-15,137,291.52	-6,231,371.38
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-142,982,145.90	310,777,912.71

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,611,390,446.00	3,148,087,535.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	850,911,346.00	2,263,558,535.00
120	Нийтлэг татварын бус орлого	850,911,346.00	2,263,558,535.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	850,911,346.00	2,263,558,535.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	850,911,346.00	2,263,558,535.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	760,479,100.00	884,529,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	760,479,100.00	884,529,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	760,479,100.00	884,529,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	809,390,446.00	971,684,746.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	809,390,446.00	971,684,746.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	766,951,693.50	886,970,671.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	465,626,130.08	519,620,507.00
210101	Үндсэн цалин	386,329,597.71	421,047,561.00
210104	Урамшуулал	00.00	21,070,474.00
210105	Гэрээт ажлын хөлс	79,296,532.37	77,502,472.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,347,045.86	64,392,190.00
210201	Тэтгэврийн даатгал	38,843,738.23	44,162,109.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,485,475.99	4,455,285.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,773,436.24	4,593,707.00
210204	Ажилгүйдлийн даатгал	929,373.09	1,016,461.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,315,022.31	10,164,628.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,949,803.86	53,189,428.36
210301	Гэрэл, цахилгаан	5,549,823.00	17,649,841.84
210302	Түлш, халаалт	43,368,025.06	32,348,528.52
210303	Цэвэр, бохир ус	3,031,955.80	3,191,058.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,860,691.10	70,128,384.00
210401	Бичиг хэрэг	7,482,935.60	12,093,728.00
210402	Тээвэр, шатахуун	11,332,829.00	32,603,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,176,376.50	6,314,435.00
210404	Ном, хэвлэл	4,292,600.00	15,987,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,095,950.00	2,410,021.00
2105	Нормативт зардал	345,000.00	368,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	345,000.00	368,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,065,370.00	17,968,070.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	2,065,370.00	12,968,070.00
2107	Томилолт, зочны зардал	13,219,305.00	17,264,640.00
210702	Дотоод албан томилолт	8,289,080.00	12,268,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,930,225.00	4,995,840.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,975,686.60	101,638,554.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,282,836.60	100,855,594.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	203,250.00	237,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,600.00	194,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	120,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,562,661.00	42,400,898.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,313,661.00	41,131,898.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,249,000.00	1,269,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,438,752.50	84,714,074.64
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	37,778,752.50	74,414,074.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,660,000.00	10,300,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,660,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	10,300,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	802,000,000.00	2,176,402,789.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	802,000,000.00	2,176,402,789.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	802,000,000.00	2,176,402,789.00
2200	Дотоод эх үүсвэрээр	802,000,000.00	2,176,402,789.00
220001	Барилга байгууламж	802,000,000.00	2,176,402,789.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-802,000,000.00	-2,176,402,789.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	441,311,039.18	322,774,563.60	148,567,376.89	00.00	912,652,979.67
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	441,311,039.18	322,774,563.60	148,567,376.89	00.00	912,652,979.67
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,949,669.82	00.00	-6,949,669.82
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,930,039.18	641,774,735.34	1,233,767,771.19	00.00	2,352,472,545.71
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,930,039.18	641,774,735.34	1,233,767,771.19	00.00	2,352,472,545.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	476,930,039.18	641,774,735.34	1,233,767,771.19	00.00	2,352,472,545.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	310,777,912.71	00.00	310,777,912.71
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,930,039.18	641,774,735.34	1,544,545,683.90	00.00	2,663,250,458.42

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	888,529,000.00	842,308,381.36	46,220,618.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	888,529,000.00	842,308,381.36	46,220,618.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	878,229,000.00	832,008,381.36	46,220,618.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	532,931,600.00	519,620,507.00	13,311,093.00
210101	Үндсэн цалин	425,688,300.00	421,047,561.00	4,640,739.00
210104	Урамшуулал	28,443,300.00	21,070,474.00	7,372,826.00
210105	Гэрээт ажлын хөлс	78,800,000.00	77,502,472.00	1,297,528.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,167,100.00	64,392,190.00	6,774,910.00
210201	Тэтгэврийн даатгал	48,380,800.00	44,162,109.00	4,218,691.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,557,200.00	4,455,285.00	101,915.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,696,600.00	4,593,707.00	1,102,893.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,139,300.00	1,016,461.00	122,839.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,393,200.00	10,164,628.00	1,228,572.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,875,400.00	53,189,428.36	16,685,971.64
210301	Гэрэл, цахилгаан	21,409,800.00	17,649,841.84	3,759,958.16
210302	Тулш, халаалт	42,325,200.00	32,348,528.52	9,976,671.48
210303	Цэвэр, бохир ус	6,140,400.00	3,191,058.00	2,949,342.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,932,700.00	54,128,384.00	5,804,316.00
210401	Бичиг хэрэг	12,212,400.00	12,093,728.00	118,672.00
210402	Тээвэр, шатахуун	16,604,300.00	16,603,000.00	1,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,611,200.00	6,314,435.00	5,296,765.00
210404	Ном, хэвлэл	16,118,000.00	15,987,200.00	130,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	720,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,666,800.00	2,410,021.00	256,779.00
2105	Нормативт зардал	368,000.00	368,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	368,000.00	368,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,000,000.00	17,968,070.00	31,930.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	13,000,000.00	12,968,070.00	31,930.00
2107	Томилолт, зочны зардал	17,843,200.00	17,264,640.00	578,560.00
210702	Дотоод албан томилолт	12,843,200.00	12,268,800.00	574,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00	4,995,840.00	4,160.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,811,000.00	73,922,454.00	1,888,546.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,160,000.00	73,139,494.00	1,020,506.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	237,960.00	412,040.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	650,000.00	194,400.00	455,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	120,600.00	400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	323,000,000.00	311,547,708.00	1,145,292.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.00	29,885,708.00	114,292.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,300,000.00	1,269,000.00	1,031,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,000,000.00	103,000,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,300,000.00	10,300,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,300,000.00	10,300,000.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	888,529,000.00	846,750,247.90	41,778,752.10
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	888,529,000.00	846,750,247.90	41,778,752.10
132001	Орон нутгийн төсвөөс	888,529,000.00	846,750,247.90	41,778,752.10
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	62	61	01.00
620001	Удирдах ажилтан	07	07	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21	20	01.00
620003	Үйлчлэх ажилтан	14	14	00.00
620004	Гэрээт ажилтан	20	20	00.00

4.6 Нэмэлт санхүүжилтийн харилцах данс

SORT_ID	ҮЗҮҮЛЭЛТ	МӨР	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		-	54,962,290.00	(54,962,290.00)	-
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		-	54,962,290.00	(54,962,290.00)	-
4	Бараа, үйлчилгээний зардал		-	54,962,290.00	(54,962,290.00)	-
22	Хангамж, бараа материалын зардал		-	16,000,000.00	(16,000,000.00)	-
24	Тээвэр (шатахуун)		-	16,000,000.00	(16,000,000.00)	-
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		-	27,716,100.00	(27,716,100.00)	-
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		-	27,716,100.00	(27,716,100.00)	-
53	Бараа үйлчилгээний бусад зардал		-	11,246,190.00	(11,246,190.00)	-
54	Бараа үйлчилгээний бусад зардал		-	11,246,190.00	(11,246,190.00)	-
84	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	2,176,402,789.00	(2,176,402,789.00)	-
85	Дотоод эх үүсвэрээр		-	2,176,402,789.00	(2,176,402,789.00)	-
86	Барилга байгууламж		-	2,176,402,789.00	(2,176,402,789.00)	-
98	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		-	2,263,558,535.00	(2,263,558,535.00)	-
111	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		-	2,263,558,535.00	(2,263,558,535.00)	-
113	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	2,263,558,535.00	(2,263,558,535.00)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	-	-
129	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	-	-
130	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		-	-	-	-
131	БАЙГУУЛЛАГЫН ТОО		-	-	-	-
134	АЖИЛЛАГСДЫН ТОО					
135	Удирдах ажилтан					
136	Гүйцэтгэх ажилтан					
137	Үйлчлэх ажилтан					